



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

“АСЕ энд Т капитал ҮЦК” ХХК-ийн харилцагчдыг шилжүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны брокер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам”-ын 5.4 дэх хэсгийг тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон “АСЕ энд Т капитал ҮЦК” ХХК-ийн харилцагч /1,840/-ийн дансыг “Таван богд капитал ҮЦК” ХХК-д шилжүүлэхийг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авагч /Б.Долгорсүрэн/, “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “Таван богд капитал ҮЦК” ХХК /Г.Мөнх-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай:

1/ Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон “АСЕ энд Т капитал ҮЦК” ХХК-ийн харилцагчдын данс нээсэн болон үнэт цаасны арилжааны хэлцлийн анхан шатны баримтыг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүлээлцэх;


2/ Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон “АСЕ энд Т капитал ҮЦК” ХХК-ийн харилцагчдыг нэмэлт төлбөргүйгээр дансаа нээлгэж, үнэт цаасны арилжаанд оролцох боломжоор хангах;

3/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 87 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам”-д заасан үүргээ чанд биелүүлж ажиллах.

3. Шилжүүлэн авсан харилцагчдад шаардлагатай мэдээллийг 2022 оны нэгдүгээр улиралд багтаан хүргэж ажиллахыг “Таван богд капитал ҮЦК” ХХК /Г.Мөнх-Эрдэнэ /-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Г.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



1510000000000